

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван найм дугаар сургуулийн 20223 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: ОРА-2024/90/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2024 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.22

№ 23

танай

-ны №

-т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН АРВАН НАЙМ
ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.НАНСАЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван найм дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван найм дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван найм дугаар сургуулийн 2023 оны үйл ажиллагааны зарцуулах баталсан төсөв, төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, төсвийг 9.8 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэл 90.2 хувьтай тайлагнаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 112,802.6 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

Аудитын гол асуудал

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 12.9 хувиар өсөж, төсвийн хуваарийг 9 удаа өөрчлөн, оны эцэст төсвийн

хуваарьт өөрчлөлт оруулж, эрх нээснээс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 432 хүүхдээр тооцсон боловч 662 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	107,987,061.89	215,945,668.41
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,935,222,701.89	2,029,390,660.24
	Нийт хөрөнгийн дүн	2,043,209,763.78	2,245,336,328.65
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,070,800.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,043,209,763.78	2,244,265,528.65
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,043,209,763.78	2,244,265,528.65
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,166,928,778.93	1,648,169,865.40
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,123,719,315.15	1,446,896,267.19
	Үйл ажиллагааны үр дүн	2,043,209,463.78	201,273,598.21
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	217,833.34
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,043,209,463.78	201,055,764.87
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,039,380,728.34	1,039,380,728.34
	Тайлант оны үр дүн	-	201,055,764.87
	Эцсийн үлдэгдэл	1,905,517,755.97	2,244,265,528.65
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,156,077,491.00	1,486,074,200.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,103,111,511.00	1,340,863,698.38
	Үйл ажиллагааны ЦМГ	52,965,980.00	145,210,501.62
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	36,831,000.00	32,408,000.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	52,965,980.00	145,210,501.62
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	16,134,980.00	112,802,501.62
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,134,980.00	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,134,980.00	128,937,481.62
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,261,225,800.00	1,373,270,044.85
	Урсгал зардал	1,261,225,800.00	1,340,862,044.85
	Хөрөнгийн зардал	-	32,408,000.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,468,175,500.00
	Улсын төсвөөс санхүүжих		1,407,122,000.00
	Орон нутгийн төсвөөс	-	61,053,500.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,134,980.00

Гурав. Аудитын илрүүлэлт

3.1 Төлбөрийн акт:

Илрүүлэлт-1:

Нягтлан бодогч, нярав нарт тайлан балансын урамшууллыг 222.5 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д " хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-2:

Үндэслэлгүй тушаал шийдвэр гарган 1,082.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага:

Илрүүлэлт-1:

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаар нийт багш, ажилтан албан хаагчдад онлайн сургалт зохион байгуулж 20,564.6 мянган төгрөг шилжүүлэн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-д "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-2:

Байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалд 2023 оны хагас жилийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д

									/сая төгрөгөөр/
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хувулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван найм дугаар сургууль								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван найм дугаар сургууль	1	20,564.6			1	20,564.6		
Дүн	1	20,564.6			1	20,564.6		
Нийт дүн	1	20,564.6			1	20,564.6	1	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын арван найм дугаар сургууль	1	1			1			
НИЙТ		1	1			1			

